213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		3,437,298.00

213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		16,192,151.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	169862792.35	275,327,139.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	169862792.35	275,327,139.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	98901838.35	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28938593.00	74,951,674.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38179721.00	47,246,465.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		152,829,000.00
	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3842640.00	
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		20,390.58
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		20,390.58

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд авлага, шатахууны зарцуулалт, дотоод хяналт, зээлийн эргэн төлөлт, Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор А.Нарандэлгэр 2022 оны 3 дугаар сарын 18-наас 2022 оны 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 1/48 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Алтай сумын засаг дарга нь "Стандарттай шинэ Ховд" хөтөлбөрийн хүрээнд төрөлх сумын төвөө үйлдвэрлэл, бизнес, худалдаа үйлчилгээ нь стандарттай, ногоон байгууламж, дэд бүтцийн хөгжил сайтай, соёлтой, эрүүл, аюулгүй төв, суурин болгон хөгжүүлж "Монгол

улсын тэргүүний сум болгох" зорилготойгоор төрийн үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*
- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Алтай сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2021 оны 04 дүгээр сард дотоод хяналт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 3345.5 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 66.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 53.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Алтай сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 316.7 сая төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн дансдууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	161.4	281.3	119.90	174%
Авлага	232.5	301.8	69.30	130%
Бараа материал	379.0	421.9	42.90	111%
Үндсэн хөрөнгө	10,546.7	10,631.3	84.60	101%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	11,319.6	11,636.3	316.70	103%
Богино хугацаат өр төлбөр	16.1	36.1	20.00	224%
Цэвэр хөрөнгө, өмч	11,303.5	11,600.2	296.70	103%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,319.6	11,636.3	316.70	103%

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 161.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 281.3 сая төгрөг болж 119.9 сая төгрөгөөр буюу 74 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 279.9 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд, арилжааны банкны дансанд 1.2 сая төгрөг байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 232.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 301.8 сая төгрөг болж 69.3 сая төгрөг буюу 30 хувиар өссөн байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

сая. төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.10	1.3	1.2
Төлбөртэй үйлчилгээний авлага		36.3	36.3
Байгууллагаас авах авлага	2.40	14.1	11.7
Хувь хүмүүсээс авах авлага	3.50	2.8	(0.7)
Татаас санхүүжилтийн авлага	17.5	3.4	(14.1)
Дүн	23.5	57.9	34.4
Тусгай зориулалтын сан	180.6	172.1	(8.5)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	28.3	71.8	43.5
Цалингийн урьдчилгаа			-
Дүн	208.9	243.9	
АВЛАГЫН НИЙТ ДҮН	232.4	301.8	34.4

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 172.1 сая төгрөгийн насжилт өндөртэй байгаа авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага, малжуулах төслийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 180.6 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 15.0 сая төгрөгийн зээл олгож, 25.3 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн

төлөгдөж, оны эцэст 172.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС-гийн авлагад бүртгэлтэй үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааны эхний үлдэгдэл 28.3 сая төгрөгөөс тайлант онд 26.3 сая төгрөгийн авлагыг барагдуулж 69.8 сая төгрөгийн 3 ажлын санхүүжилтийг олгож, хөрөнгө хүлээн аваагүйтэй холбоотой авлагаар нэмж бүртгэн, 71.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 421.9 сая төгрөг болж 42.9 сая төгрөгөөр өссөн нь 55.9 сая төгрөгөөр эм боох материал, аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 368.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 42.0 сая, малын үнийг дахин үнэлж 3.6 сая төгрөгөөр нийт 414.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 371.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 10,546.7 сая төгрөг байсан бол оны эцэст 10,631.3 сая төгрөг болж 84.6 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 3.9 сая төгрөгөөр төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, 434.5 сая төгрөгөөр шилжүүлэн авсан, үнэ төлбөргүй хандиваар нэмэгдэж, акталсан, балансаас балансад шилжүүлсэн 2.5 сая төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 16.1 сая, эцсийн үлдэгдэл 36.1 сая төгрөг болж 20.0 сая төгрөгөөр өссөн байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 36.1 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой байгууллагад төлөх өглөгүүд байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 11,303.5 сая төгрөг байсан оны эцэст 11,600.2 сая төгрөг тайлант онд 296.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 312.5 сая төгрөгийн ашигтайтай, өмнөх үеийн үр дүн рүү 15.8 сая төгрөгөөр залруулсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,845.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,845.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18 өдрийн 2/05 тоот тогтоолоор 2,835.5 сая төгрөгөөр анх баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,970.8 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталсан байна. Аймгийн Засаг даргын А/842 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийж Ерөнхий

боловсролын сургуулийн төсөвт 12.5 сая төгрөгийг хасаж тодотгон орон нутгийн нийт төсөв 2953.3 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,958.3 сая төгрөгийн төсөв баталснаас 1,675.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 788.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 35.3 сая төгрөгийг ЭМДС-аас, 222.6 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 4.4 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 185.5 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 47.1 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 3: Төлөвлөгөө, гүйцэтгэл

сая. төгрөг

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Улсын төсвөөс санхүүжих	1,675.0	1,632.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,675.0	1,632.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,011.0	997.1
Орон нутгийн төсвөөс	788.4	774.5
Орон нутгийн хөгжлийн сан	222.6	222.6
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	35.3	31.2
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35.3	31.2
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	237.0	131.8
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	4.4	4.1
Туслах үйл ажиллагааны орлогоос	185.5	127.7
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	47.1	
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	2,958.3	2,792.1

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,632.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 774.5 сая төгрөг, ОНХС-ийн санхүүжилт 222.6 сая төгрөг, ЭМДС-аас санхүүжих 31.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 4.1 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 127.7 сая төгрөг нийт 2,792.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,732.7 мянган төгрөгийг зарцуулж 56.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,732,7 сая төгрөг буюу 92,4 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 15.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6.8, бараа хангамж, бараа материалын зардал 0.9, томилолтын зардал 0.5, нормативт зардал 35.3, бараа үйлчилгээний бусад зардал 1.9, хөрөнгийн зардал 95.6, эргэж төлөгдөх зээл 68.1 сая төгрөгөөр буюу нийт 225.6 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 4.4, туслах үйл ажиллагааны орлого 185.5 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 4.1 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 127.7 сая төгрөгөөр нийт 131.8 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн орлогын 100.0 сая төгрөгийг Талст молор ХХК-тай байгуулсан гэрээнээс, 25.2 сая төгрөгийг СХС-ийн зээл, зээлийн хүүгийн орлого, 4.1 сая төгрөгийг ЗДТГ-ын өөрийн орлого, 2.4 сая төгрөгийг ЕБС-ийн өөрийн орлогоор бүрдүүлэн ажиллажээ.

Алтай сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 3/03 дугаар тогтоолд Алтай сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 101.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 193.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 191.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	101.4	193.3	(91.9)
Нийт орлого ба тусламжийн дүн	101.4	193.3	(91.9)
Татварын орлого	94.4	183.7	(89.3)
Орлогын албан татвар	6.2	30.8	(24.6)
Хувь хүний орлогын албан татвар	4.2	0.30	3.9
Үйл ажиллагааны орлого	2.0	30.5	(28.5)
Хөрөнгийн албан татвар	48.1	54.1	(6.0)
Бууны албан татвар	3.1	3.0	0.1
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	45.0	51.1	(6.1)
Малын тоо толгойн албан татвар	-	22.5	(22.5)
Малын тоо толгойн албан татвар	-	22.5	(22.5)
Бусад татвар, төлбөр, хураамж	5.1	6.3	(1.2)
Улсын тэмдэгтийн хураамж	2.6	2.7	(0.1)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	1.0	2.1	(1.1)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.5	1.5	(0.0)
Газрын төлбөр	-	0.6	(0.6)
Газрын төлбөр	-	0.6	(0.6)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	35.0	69.3	(34.3)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.0	0.6	0.4
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	4.1	16.5	(12.4)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	29.9	52.2	(22.3)
Татварын бус орлого	7.0	9.6	(2.6)
Нийтлэг татварын бус орлого	7.0	9.6	(2.6)
Торгуулийн орлого	7.0	9.6	(2.6)

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 193,3 сая төгрөг буюу 91,9 сая төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь Үйл ажиллагааны орлого 28.5 , иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 6.1, хөрөнгийн албан татварын орлого 6.0, малын тоо толгойн орлого 22.5 , түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны орлого 1.1 сая төгрөгөөр улсын тэмдэгтийн хураамж 0.1, газрын төлбөр 0.6, байгалийн нөөц ашигласны төлбөр 12.4, ан амьтны нөөц ашигласны төлбөр 22.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж, Хувь хүний орлогын албан татвар 3.9 , ус рашааны нөөц ашигласны төлбөр 0.6 сая төгрөгөөр тасалжээ.

Татварын бус орлогыг 7.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 9.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж 2.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЭМГ-аас 36.9 сая төгрөг, ЭМДС-ын орлогоор Ковид-2019 цар тахлын үеэр ажилласан илүү цаг, томилолт, вакцины урамшуулалд 152.8, БСУГ-аас ЕБС болон СӨБ-ийн байгууллагад ажиллаж байгаа багш нарын тэтгэмж 18.3 өмнөх оны авлага буюу татан төвлөрүүлэлтээс 17.7, номын түрээсийн орлого 3.6, тендерийн баримт бичгийг худалдсаны орлого 0.8, бусад орлогоос 64.8 сая төгрөг нийт 294.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 275.3 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 16.2 сая төгрөгийг, улсын төсөвт 3.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2011-2020 онуудад олгосон 60 зээлдэгчийн 475.7 сая төгрөгийн зээл олгогдсоноос 1 иргэн нас барсан, 36 зээлдэгч зээл бүрэн төлж дууссан, 3 иргэний 31.4 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй, 21 иргэний 130.9 сая төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. “Тоосгон уул” ХХК-тай 15 жилийн хугацаатай концессийн гэрээ байгуулан сумын төсөвт байгууллагуудыг халаалт дулаанаар ханган ажиллаж тайлант онд өр үүсээгүй тайлагнасан ч төсөвт байгууллагуудад батлагдсан төсвөөр гэрээ байгуулан зардлыг санхүүжүүлсэн байна.
3. Тайланд хугацаанд 505 хүн Ковид 19 цар тахлаар өвчилж 203.1 сая төгрөгийн нэг удаагийн эм, эмнэлгийн хэрэгсэл урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Алтай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд аймгийн ХО-аар 145.2 сая төгрөгийн өртөгтэй халуун усны барилгын ажлыг “Талст чиглэл ХХК”, 33.7 сая төгрөгийн гүний худаг гаргах ажлыг “Эвлэл ХХК”, 49.5 сая төгрөгийн Гэр хороололд доторлогоотой суваг шинээр хийх ажлыг “БЕСА” ХХК тус тус гүйцэтгэж данс бүртгэлд тусгасан, сумын Эрүүл мэндийн төв Ковид-19 цар тахлын үйлчилгээ үзүүлсний төлбөрт ЭМДС-аас авах 36.3 сая төгрөгийн авлага үүссэн асуудлууд нь үлэмж нөлөө үзүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллээс 156 хугацаандаа оруулсан 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 132.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 5 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 ОНӨААТҮГ нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 6 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-3 (сумын 12 жилийн сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг, ЭМТөв) (нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Алтай сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 30.5 сая төгрөгийн 12 алдаа зөрчил илэрч, 17.7 мянган төгрөгийн 5 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 12.8 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 1.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 төлбөрийн акт тогтоон, 2.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгч, 8.2 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Алтай сумын 12 жилийн сургууль	4	10.7	-	-	-	-	-	-	4	10.7
2	Алтай сумын хүүхдийн цэцэрлэг	3	3.3	-	-	1	0.1	-	-	2	3.2
3	Алтай сумын ЭМТ	8	27.2	4	17.7	2	1.7	1	2.8	1	5.0
Дүн		15	41.2	4	17.7	3	1.8	1	2.8	7	18.9

Эх сурвалж: Алтай сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 295.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.9 сая төгрөгийн 2 алдаа зөрчилд 2 төлбөрийн акт, 130.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 64.5 сая төгрөгийн 9 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс бараа материал худалдан авч бэлтгэхдээ нярваар орлого аваагүй 30.7 сая төгрөг,
2. Ажилтан албан хаагчдын хувийн унаанд шатахуун олгож албан хэрэгцээнд зарцуулсан болон албаны авто машинд шатахуун олгохдоо жолоочийн тооцоог үнэн зөв бодож хянаагүй, жолоочийн замын хуудас дутуу, явсан ажлын тайланг хавсаргаж оруулаагүй 2.3 сая төгрөг,
3. Бэлтгэн нийлүүлэгчээс бараа материал худалдан авахдаа төлбөрийн баримтаар бүрэн гүйцэд баталгаажуулаагүй 65.3 сая төгрөг нийт 98.3 сая төгрөг

Шийдвэрлэсэн нь: Залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

1. Засаг даргын Тамгын газрын дарга Д.Баатарсүрэнгийн ээлжийн амралтын хугацаанд газрын даамал Б.Түмэндэмбэрэлийг түр хугацаагаар хариуцуулж гэрээгээр авч ажиллуулж олгосон цалин 0.3 сая төгрөг, Засаг дарга Х.Түмэндэлгэрт 2 хоногийн албан томилолт илүү олгосон 0.03 сая төгрөг, Засаг даргын орлогч Г.Булгансүхэд анхан шатны баримтаар нотлохгүй бүрэн бус, томилолтын хуудсаар албан томилолт олгосон 0.2 сая төгрөг, туслах үйл ажиллагааны түрээсийн орлогын 40 хувийг дутуу төвлөрүүлсэн 0.7 сая төгрөг, нийт 1.3 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн нь нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 20 зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах", гэсэн заалтуудыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Сумын ИТХ-ын дарга Б.Бат-Эрдэнэд ээлжийн амралтын олговрыг цалинтай давхардуулан олгосон 0.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 2-т "Ажил олгогч нь бүх ажилтныг ажлын жил бүр ээлжийн амралтаа заавал биеэр эдлэх бололцоогоор хангаж, эдлүүлнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Илрүүлэлт: 4.3.1 СХС-ийн зээлийн үлдэгдэлтэй байгаа 24 зээлдэгчээс 21 нь хугацаа хэтэрсэн байгаа ба зээлийн гэрээнд тусгасан алдангийн хэмжээ нь жилийн 1 хувь байгаа нь зээлийг хугацаандаа төлж барагдуулах хөшүүрэг болохгүй байна. Зээлдэгч нарын картыг хөтлөөгүй, СХС-ийн программын ашиглалт хангалгүй, зэрэг зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2016 оны 153-р тогтоолын 1.7-д "Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын засаг

дарга болон зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд тодорхой тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Сум хөгжүүлэх сангаас зээл авч хугацаандаа төлөөгүй 21 зээлдэгчийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн сангийн эргэцийг сайжруулан ажиллах, СХС-ийн программын ашиглалтыг сайжруулж, зээлийн гэрээг шинэчлэх албан шаардлага өгөв.

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт1: Алтай сумын ТТЗ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд СХС-ийн зээлийн авлагыг илүү тооцоолсон нийт **0.5** сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 20 зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах", гэсэн заалтууд хэрэгжээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн тайланд авлагын үлдэгдлийг үнэн зөв тооцоолж, тайланд тусгаж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллах.

Илрүүлэлт2: Алтай сумын ЗДТГ-ын тайланд он дамжсан насжилт өндөртэй , эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг тодорхойлж барагдуулаагүй **2.0** сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д " Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Алтай сумын ЗДТГ-ын тайланд тусгагдсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Илрүүлэлт3: Алтай шим ус ОНӨААТҮГ нь тайланд он дамжсан авлагыг тодорхойлж барагдуулаагүй **0.7** сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д " Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Алтай шим ус ОНӨААТҮГ-ын тайланд тусгагдсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

4.4.2 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 4: Орон нутгийн хөгжлийн сангаас Иргэдийн санал авч, эрэмбэлээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж, зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах", Сангийн сайдын 2021 оны 05 сарын 24-ний өдрийн 86 дугаар тогтоолын 4.3.2-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн

орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" гэсэн заалт гэсэн заалтуудыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг мөрдөж, сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах талаар анхааран ажиллах,

4.4.3 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт 5: Сумын Соёлын төв 2021 онд батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл олгосон 1.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-д "Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиг үүргийн давхардлыг арилгах ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох" гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Зөвлөмж: Батлагдсан орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл олгох.

4.4.4 Төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 6: Сумын Соёлын төв нь тайлант онд 0.1 сая төгрөгийн шатахууны зардал батлагдсан байхад бусад зардлуудаас гүйлгэн 1.1 сая төгрөгийн шатахуун зарцуулж, 0.9 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулжээ. Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалт

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллын дагуу төсөвт журмын дагуу зохицуулалт хийж зардлыг санхүүжүүлэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж тайлагнах

4.4.5 ЗГ-ын 2021 оны 43-р тогтоолын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 7: ЗДТГ нь батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, хөрөнгө бэлтгэсэн, төсвийг үрэлгэн зарцуулсан зэрэг 41.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг баримталж ажиллах.

Илрүүлэлт 8: ИТХ нь батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй 6.0 сая төгрөг, төсвийг үргүй зарцуулсан 3.6 сая төгрөг, нийт 9.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг баримталж ажиллах.

4.4.6 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт 9: ТТЗ нь Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолын дагуу санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16.5.6 -д "Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтын зохион байгуулах журам"-тай байна, 1.5-д "Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 3-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая. төгрөгөөр/

д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗахирагч	1	-							1	0
2	Алтай ЗДТГ	6	143.2	3	98.5	1	1.3		-	2	43.4
3	Алтай ИТХ	2	10.3			1	0.6			1	9.7
4	Алтай Соёлын төв	2	2.2							2	2.2
5	Алтай ОНХС	1	8.0							1	8.0
6	Алтай СХС	2	131.4					1	130.90	1	0.5
7	Алтай шим ус									1	0.7
	Дүн	15	295.8	3	98.5	2	1.9	1	130.9	9	64.5

Ховд аймаг дахь Төрийн аудитын газар